



# I БҮЛЭГ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА

## ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Нийлүүлэх бараа нь дор дурдсан техникийн тодорхойлолт, стандартад нийцсэн байна.

1. Худалдаа үйлчилгээ эрхлэх зөвшөөрөлтэй байх. / Аж ахуйн нэгж байна /
2. Хүнсний дэлгүүрийн тохирлын гэрчилгээтэй байна.
3. Шаардлага хангасан хүнсний агуулах, зориулалтын хөргөгч, хөргүүртэй байна.
4. Хүнсний зориулалтын агуулах зооринд мах болон хүнсний материалын нөөцтэй байх.
5. Жин хэмжүүр нь баталгаажсан байна.
6. Хүнсний материалын хэрэгцээг тасралтгүй хангаж байх
7. Бараа бүтээгдэхүүний үнэ нь зах зээлийн хамгийн бага дундаж үнэ байх.
8. Хугацаа дууссан бүтээгдэхүүн, чанарын шаардлага хангахгүй / норсон, хатсан, хөгцөрсөн, жин дутуу, гашилж ээдсэн зэрэг / бүтээгдэхүүн нийлүүлсэн тохиолдолд үл маргах журмаар хэрэглэгчийг хохиролгүй болгоно.
9. Тухайн сарын хэрэгцээнээс шалтгаалан сарын төсвөөс хэтрэх тохиолдолд тасралтгүй хангаж байх.

| Багцын дугаар | Бараа болон холбогдох үйлчилгээний нэр | Техникийн тодорхойлолт болон стандарт   |
|---------------|--|---|
| Багц №1       | Мах, махан бүтээгдэхүүн                | <ul style="list-style-type: none"><li>- Махыг хэсэглэж ангилсан байдлаар нийлүүлэх тохиолдолд MNS 2456:2009, MNS 2457:2009 стандартуудын шаардлагыг хангасан байна</li><li>- Эрүүл ахуй, аюулгүй байдлын үндсэн шаардлага хангасан, эрүүл малаас бэлтгэсэн байна.</li><li>- Мал эмнэлэг, гарал үүслийн гэрчилгээ, хүнсний лабораторийн шинжилгээний бичигтэй байна.</li><li>- Загсаасан буюу сэрвээсэн эсвэл хөргөсөн, хөлдөөсөн мах байна.</li><li>- Агуулах зооринд махны нөөцтэй байх</li><li>- Нөжирч хурсан цус, сэвс, үс, шороо зэрэг гадны бохирдолгүй, гадаргуу нь урагдаж гэмтээгүй байна.</li><li>- Эрүүл ахуйн шаардлага хангасан зориулалтын тээврийн</li></ul> |

|         |                             |  |
|---------|-----------------------------|--|
|         |                             | <p>хэрэгслээр тээвэрлэх</p> <ul style="list-style-type: none"> <li>- Дулааны улиралд зориулалтын хөргүүрт хадгалах</li> <li>- Тээвэрлэлт, хадгалалт, борлуулалтын явцад технологийн горимыг чан мөрдөнө.</li> </ul> <p>Мах бүтнээр бөөндөхөд дөрвөн шаант олон уулзахын ясыг хасаж тооцох.</p>   |
| Багц №2 | Сүү, сүүн бүтээгдэхүүн      | <ul style="list-style-type: none"> <li>- Сүү нь түүхий сүүний техникийн шаардлага MNS 4228:2003 стандартыг хангасан байна.</li> <li>- Түүхий сүү нь малаас хүнд халдварлах өвчин болон малын гоц халдварт өвчнөөр өвчлөөгүй эрүүл бүсээс бэлтгэсэн байна.</li> <li>- Сүү, сүүн бүтээгдэхүүн нь итгэмжлэгдсэн лабораторит улирал тутам шинжлүүлсэн байх</li> <li>- Зориулалтын сав, баглаа, боодолтой байна.</li> </ul> <p>Хүнсний нэмэлт агуулаагүй байна.</p> <ul style="list-style-type: none"> <li>- Ариун цэврийн шаардлага хангасан тээврийн хэрэгслээр тээвэрлэнэ.</li> <li>- Тээвэрлэлт, хадгалалт, борлуулалтын явцад технологийн горимыг чанд мөрдөнө.</li> <li>- Хүнс хөдөө аж ахуйн газрын итгэмжлэгдсэн лабораторын шинжилгээний бичиг, дүгнэлт ирүүлэх.</li> <li>- Малын вакцин, тарилга туулгад хамрагдсан тухайд бүтээгдэхүүнийг нийлүүлэхгүй байх ба урьдчилан мэдэгдэнэ.</li> </ul> |
| Багц №3 | Будаа, гурилан бүтээгдэхүүн | <ul style="list-style-type: none"> <li>- Эрүүл ахуйн шаардлага хангасан, сав баглаа боодол, шошготой байна.</li> <li>- Сав баглаа гэмтээгүй байх, хугацаа дуусаагүй, эрүүл ахуй ариун цэврийн шаардлага хангасан байх.</li> <li>- Ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага хангасан тээврийн хэрэгслээр тээвэрлэнэ.</li> <li>- Жилд нэг удаа шинжилгээнд хамрагдсан шинжилгээний бичигтэй байх.</li> </ul>   |
| Багц №4 | Төмс, хүнсний ногоо         | <ul style="list-style-type: none"> <li>- Нийлүүлэх хүнсний ногоо нь орон нутаг тариалагдсан, MNS0255:2007 стандартын шаардлага хангасан байх</li> <li>- Итгэмжлэгдсэн лабораторит улирлаар шинжлүүлсэн хүнсний аюулгүй байдлын шаардлага хангасан байх</li> <li>- Хортон, хөнөөлт шавьжаар гэмтэж, бохирлогдоогүй, бүтэн, хуурай, сортынхоо хэлбэр, дүрсийг хадгалсан байх</li> <li>- Гэмтэж муудаж зөөлрөөгүй, соёолоогүй, хайрагдаагүй байх</li> </ul>   |

|                |                                  |   |
|----------------|----------------------------------|---|
| Багц<br>№5, №6 | Жимс,<br>жимсгэнэ<br>болон бусад | <ul style="list-style-type: none"><li>- Ариун цэвэр эрүүл ахуйн шинжилгээнд оруулсан байх</li><li>- Хортон, хөнөөлт шавьжаар гэмтээгүй, эрүүл, хагаралтгүй, хөгшрөөгүй, наалдсан шороогүй, хуурай, сортынхоо хэлбэр, дүрсийг хадгалсан байна</li><li>- Зориулалтын эрүүл ахуйн шаардлага хангасан тээврийн хэрэгслээр тээвэрлэх</li></ul> |
|----------------|----------------------------------|---|